



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2025 оны ээлжит 26 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 26 дугаар хуралдаан 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 26 дугаар хуралдаанаар /2025-12-16/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2 жил үйл ажиллагаа явуулаагүй үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай санал, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай санал, дүгнэлт); ХХЗХ-той холбоотой шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны явцын талаар танилцуулга (2025 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар); “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай” (2 дахь хэлэлцүүлэг, Хавсралтууд 01-07: ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн төсөл) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 8 (Тогтоол №266-273, 2025-12-16) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 26 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2 жил үйл ажиллагаа явуулаагүй үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай санал, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай санал, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 266 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юнител ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 14300003 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8, 12

дугаар зүйлийн 12.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юнител ХХК: Хөдөлгөөнт үүрэн холбооны сүлжээний радио станцад ашиглах радио давтамжийн 902.6-909.8МГц/947.6-954.8МГц-ийн зурвасын “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 24310003 тоот тусгай зөвшөөрлийг) 20 жилийн хугацаагаар сунгасан;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 268 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд (Такс тайм ТМЗ ХХК: 1900-1288) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 269 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд олгосон (Эйрлинк монголиа ХХК: 1800-1818) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.9 дэх заалт, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 270 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай дугаарын (Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн “1800-1063” дугаарлалт бүхий 30010708 тоот тусгай дугаар ашиглах) бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 271 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 272 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Мобинет ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 14500027 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 26 дугаар хуралдаанд тус хорооны ЗУХАГ, Хуулийн хэлтсээс “ХХЗХ-той холбоотой шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны явцын талаар танилцуулга (2025 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар)”-ыг хэлэлцүүлж, хуралдаанд сонсов. Хуралдаанаас цаашид Хорооны баталсан тогтоол, шийдвэр болон байгууллагатай холбоотой шүүхийн гомдол, маргааны шийдвэрлэлтийн явц, гарсан шүүхийн шийдвэрийг тухай бүр гишүүдэд шуурхай мэдээлэх, цахим хаягаар танилцуулга, мэдээлэл хүргүүлж ажиллахыг ЗУХАГ-т үүрэг чиглэл болгов.

Тус хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаар /2025-12-10/ Даргын 2025 оны А/266 дугаар тушаалаар байгуулагдсан тус Хорооны гишүүн, ажлын албаны дарга А.Лувсан-Очирын ахалсан ажлын хэсэг, бүтцийн ажлын албанаас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл” (Хавсралт-01-07: ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2026 оны орлого, зардлын төлөвлөгөө”-ний төсөл;

“ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”)-ийн төслийн Анхны хэлэлцүүлгийг хийж, тус хорооны хуралдааны хэлэлцүүлгийн үеэр хорооны дарга, гишүүдээс өгсөн удирдамж чиглэл, санал зөвлөмж (-Дотоод нөөцөөр гүйцэтгэж болох ажил дээр төсөв хэмнэх; -Төсвийн төлөвлөлтөд 2025 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлийг тусгаж танилцуулах; -Зайлшгүй төсөв зарцуулах шаардлагатай үйл ажиллагааг эрэмбэлэх)-ийг тусган “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай асуудлыг эцсийн хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхээр боловсруулж, Хорооны 2025 оны 12 дугаар сарын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (А.Лувсан-Очир)-т болон холбогдох бүтцийн нэгжийн газар, хэлтсийн удирдлага нарт үүрэг болгосон юм. ХХЗХ-ны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр болсон ээлжит 26 дугаар хуралдаанд Ажлын хэсгээс Хорооны 2025 оны ээлжит 25 дугаар хуралдаанаас өгсөн удирдамж, чиглэл болон санал зөвлөмжийг тусган боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө болон зардлын төсөл, байгууллагын 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай танилцуулга, санал зөвлөмж тусгасан судалгаа, “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай тогтоолын төсөл холбогдох хавсралтуудын төслийг хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай 273 тоот тогтоолыг 7 хавсралтын хамт баталж шийдвэрлэсэн болно. Энэхүү тогтоолд, “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Нэгдүгээр, “ХХЗХ-ны 2026 оны орлогын төлөвлөгөө”-г Хоёрдугаар, “ХХЗХ-ны 2026 оны зардлын төлөвлөгөө”-г Гуравдугаар, “ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ыг Дөрөвдүгээр, “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ыг Тавдугаар, “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ыг Зургаадугаар, “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийг Долоодугаар хавсралт ёсоор тус тус баталсан. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан Хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгав.” гэжээ. Тус хуралдааны 2025 оны 273 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, Хорооны үйл ажиллагааны 2026-2030 оны дунд хугацааны стратегийн зорилго, зорилтод чиглэсэн нийтдээ 2026 оны төлөвлөгөөнд үндсэн 3 ангиллын бүтээгдэхүүний 256 ажил үйлчилгээ, үйл ажиллагааг багтаан баталсан болно.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2025-12-23